



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум,
7-р баг, Жинст 0, Утас/Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.03.25 № 248

танай _____ -ны № _____ -т


ЦЭЭЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Д.БУЯНХИШИГ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Цээл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан, дүгнэлт, шийдвэрийг хүргүүллээ.

Аудитаар өгсөн шийдвэрийг хугацаанд нь хэрэгжүүлж биелэлтийн ирүүлнэ үү.

Хавсралт ... хуудастай.

ДАРГА ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Х.ТҮВШИНБАЯР



07030381

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Цээл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГАА-2022/15/-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор:	Х.Түвшинбаяр
	Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn	
	Аудитын менежер:	Д.Эрдэнэчимэг
	Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn	
	Ахлах аудитор:	Б.Цэцэгмаа
	Утас: 99177546 Цахим хаяг: Tsetsegmaab@audit.gov.mn	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөг/	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөг/	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөг/	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/.....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөг/	8
3. Аудитын тайлан	9
3.1. Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал.....	10
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга	10
3.5.1 Орлогын данс	11
3.5.2 Зардлын данс	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал.....	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт.....	13
5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлсэн сан



АЙМГИЙН ЦЭЭЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Д.БУЯНХИШИГ ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.03.25 № 180

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цээл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цээл сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

07020474

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,316,964.3	2,365,700.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	950,241.2	1,400,963.6
33	АВЛАГА	13,509.0	227,346.8
35	БАРАА МАТЕРИАЛ	218,167.3	265,196.2
36	НӨӨЦИЙН БАРАА	39,176.4	28,472.4
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	95,870.4	443,721.4
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,280,153.4	2,800,416.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,280,153.4	2,800,416.3
39200	Биет хөрөнгө	2,176,816.4	2,693,371.3
39300	Биет бус хөрөнгө	103,337.0	107,045.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,597,117.6	5,166,116.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	7,602.7	17,308.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7,602.7	17,308.2
41300	Өглөг	7,602.7	17,308.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,589,515.0	5,148,808.4
51	Засгийн газрын хувь оролцоо	3,589,515.0	5,148,808.4
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,427,260.4	1,431,238.4
51200	Хуримтлагдсан үр дүн	1,624,654.1	3,179,969.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	537,600.5	537,600.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,597,117.6	5,166,116.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,808,205.7	4,335,059.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	115,913.1	129,740.5
110	Орлогын албан татвар	87,425.1	71,028.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	87,425.1	71,028.4
113	Хөрөнгийн албан татвар	2,400.0	2,076.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	26,088.0	56,636.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	479,772.6	758,225.2
120	Нийтлэг татварын бус орлого	479,772.6	758,225.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,212,520.0	3,447,094.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,775,399.2	2,748,026.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,775,399.2	2,748,026.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,075,416.2	2,643,261.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,321,147.8	1,412,358.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	174,623.5	198,979.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	107,903.1	114,854.1
2104	Хангамж, бараа материалын зардал	119,952.0	126,325.3
2105	Нормативт зардал	62,926.1	390,586.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,744.0	31,132.4
2107	Томилолт, зочны зардал	7,322.6	12,281.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,002.2	9,918.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	241,794.9	346,825.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	699,983.0	104,764.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,032,806.5	1,587,034.0
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.0	0.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	75,823.5	31,718.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	956,983.0	1,555,315.5

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,832,581.1	3,384,809.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	115,913.1	129,740.5
110	Орлогын албан татвар	87,425.1	71,028.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	87,425.1	71,028.4
113	Хөрөнгийн албан татвар	2,400.0	2,076.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	26,088.0	56,636.2
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	7,284.7	13,347.3
1181	Газрын төлбөр	7,428.8	29,608.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	11,110.5	13,498.9
1183	Бусад татвар	264.0	182.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	87,678.8	25,644.9
120	Нийтлэг татварын бус орлого	87,678.8	25,644.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,628,989.1	3,229,424.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,958,367.5	2,241,855.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,958,367.5	2,241,855.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,841,915.4	2,137,002.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,321,147.8	1,419,151.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	174,623.5	199,693.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	108,539.1	113,547.2
2104	Хангамж, бараа материалын зардал	84,511.4	87,548.2
2105	Нормативт зардал	60,808.8	202,383.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,851.0	32,517.6
2107	Томилолт, зочны зардал	7,322.6	12,281.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,440.4	9,925.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,670.7	59,953.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	116,452.1	104,853.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	874,213.6	1,142,953.9
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	119,231.4	692,231.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	119,231.4	692,231.5
2200	Дотоод эх үүсвэрээр	119,231.4	692,231.5
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-119,231.4	-692,231.5
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	0.0
14	Бусад эх үүсвэр	0.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	0.0
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	0.0	0.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	754,982.2	450,722.4
101	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл	195,259.0	950,241.2
20	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	950,241.2	1,400,963.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,634,527.0	0.0	2,634,527.0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,995.0	0.0	-1,995.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,632,532.0	0.0	2,632,532.0
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	956,983.0	0.0	956,983.0
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,589,515.0	0.0	3,589,515.0
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,589,515.0	0.0	3,589,515.0
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,589,515.0	0.0	3,589,515.0
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	3,978.0	0.0	3,978.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	1,555,315.5	0.0	1,555,315.5
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,148,808.4	0.0	5,148,808.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,058,977.50	2,647,822.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,074,753.10	1,991,990.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,037,730.50	1,957,451.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,424,244.60	1,394,905.04
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	227,677.40	196,558.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	113,136.20	111,258.67
2104	Хангамж, бараа материалын зардал	77,867.10	75,011.67
2105	Нормативт зардал	76,338.00	74,298.27
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,886.30	47,742.70
2107	Томилолт, зочны зардал	12,890.00	11,802.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,813.00	5,377.01
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,877.90	40,497.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,022.60	34,538.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,022.60	34,538.29
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,814,224.40	655,832.52
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	170,000.00	0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,058,977.50	3,135,601.50
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,408,251.20	1,369,656.58
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,744,082.60	1,733,236.10
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	21,749.20	8,213.93
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	884,894.50	24,494.90
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		880,240.94
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,368,019.67

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	247,669.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	247,669.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	215,949.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	24,246.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,134.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,288.50
2104	Хангамж, бараа материалын зардал	12,686.50
2105	Нормативт зардал	128,235.61
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,619.90
2107	Томилолт, зочны зардал	479.06
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,548.26
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,710.27
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,720.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,720.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.36
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	247,788.36
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	247,788.36
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	118.51
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	118.51

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цээл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны тухай хуулийн холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Цэцэгмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Цээл сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 04-ны өдрийн 1/80 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цээл сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь Монгол Улсын үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн чиг үүргийг хэрэгжүүлж, нутгийн өөрөө удирдах ёсны чадавхыг дээшлүүлэх, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх ойрын бодлогыг зөв зохистой тодорхойлох иргэдийн эрх ашгийг хамгаалан, сайн сайхан амьдрах орчин бүрдүүлэх хүний хөгжлийг бүх талаар хангах чиг үүрэг бүхий аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа нэгж юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг 2020 онд баталсан. Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн чиг үүргийн байгууллагаас бусад байгууллагад даалгасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг шинэчлэн тогтоожээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын алба нь 2021 онд Бугат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цээл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал болох 2,191.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 43.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 35.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Цээл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 44 хувиар буюу 1,569.0 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,400.9 сая төгрөг болж өссөн ба энэ өсөлтөд голлон орон нутгийн хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдсэн нөлөөлсөн байна.

Авлага дансны үлдэгдэл 227.3 сая төгрөг болж өссөн нь сумын Эрүүл мэндийн төвийн төлбөртэй үйлчилгээний авлага, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал цалингийн нөхөн олговор олгож авлагаар бүртгэсэнтэй холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл 265.2 сая төгрөг болж 47.0 сая төгрөгөөр өссөн нь эм боох материал, бусад хангамжийн материалын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 438.8 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 271.2

сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 648.3 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,800.4 сая төгрөг болж 520.3 сая төгрөгөөр өссөн. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 36.4 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, дахин үнэлгээтэй холбоотой 3.9 сая төгрөгийн нэмэгдэл бүртгэж, 768.7 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсантай холбоотой байна.

Цээл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа нэгж байгууллагууд 264.8 сая төгрөгийн хөрөнгийг акталсан.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 17.3 сая төгрөг болж 9.7 сая төгрөгөөр өссөн сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанаас үүссэн өглөгийг нэмж бүртгэгдсэнтэй холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,148.8 сая төгрөг болж 1,559.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 3,179.9 сая төгрөг болсон байна.

3.5.1 Орлогын данс

Тайлант онд 129.7 сая төгрөгийн татварын орлого, 25.6 сая төгрөгийн татварын бус орлого, 3,874.0 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого нийт 4,029.4 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

3.5.2 Зардлын данс

Тайлант онд 2,748.0 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал 31.7 сая төгрөгийн үйл ажиллагааны бус зардал хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

3.5.3 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Цээл сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын “Сумын 2021 оны төсөв тодотгон батлах тухай” 10 дугаар тогтоолд зааснаар сумын төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 115.4 сая төгрөгийн татварын 1.1 сая төгрөгийн татварын бус нийт 116.5 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 130.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 112 хувиар биелүүлсэн байна.

Орлогын нэр төрлөөр гаргахад хөрөнгийн орлого 1.0 сая төгрөгөөр тасарсан байна. Аудитаар татварын бааз суурийг хамруулж үзээгүй тул орлого тасарсан үндэслэлийг тодорхойлох боломжгүй байлаа.

Орлогын гүйцэтгэлийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад өндөр дүнгээр нэмэгдсэн татварын болон татварын бус орлогын төрөл байхгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд орон нутгаас 449.6 сая төгрөгийн төсвийн дэмжлэг, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгээс 1,110.3 сая төгрөгийн эх үүсвэр авахаар тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 5.2 сая төгрөгөөр өсгөж, 1,565.1 сая төгрөгөөр баталжээ.

ГАА-2022/15/-НА-СТА-ТТЗ

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага, орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт, эмнэлгийн тусламж үйлчилгээ, соёл урлаг, сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд арга хэмжээг улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 4,058.9 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,408.2 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,369.6 сая төгрөгийг зарцуулж 38.6 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн, орон нутгийн төсвөөс 454.8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч орон нутгийн төсвийн байгууллага болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын тогтмол зардалд нийт 633.7 сая төгрөгийн санхүүжилт олгож 622.9 сая төгрөгийг зарцуулж 10.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,647.8 сая төгрөг буюу 65 хувьтай байгаа нь урсгал зардлыг 82.7 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 1,158.4 сая төгрөгөөр, эргэж төлөгдөх зээлийг 170.0 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 247.8 сая төгрөгийн орлого хүлээн авсан ба төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж ангилалд 29.8 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө ангилалд 44.3 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого ангилалд 10.9 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого ангилалд 162.8 сая төгрөгийн орлогыг тайлагнасан. Нэмэлт санхүүжилтийн орлогыг цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардалд 24.2 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 3.1 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 2.3 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 12.7 сая төгрөг, нормативт зардалд 128.2 сая төгрөг, эд хогшлын урсгал засварын зардалд 19.6 сая төгрөг, томилолт зочны зардалд 0.5 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж зардалд 4.5 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 20.7 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 31.7 сая төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 141 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд :

Цээл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн шийдвэрээс 2.5 сая төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилт хангагдаагүй байна. Энэ нь тус төвлөрүүлэн захирагчид нэгтгэгддэг нэгж байгууллагуудын татварын цахим системийн илүү төлөлттэй холбоотой бөгөөд энэ онд нэгж байгууллагын удирдлагад үүссэн зөрүүг арилгах албан шаардлага хүргүүлсэн тул нэгтгэсэн тайлангаар давхардуулан шийдвэр өгсөнгүй.

Харьяа нэгж байгууллагын тухайд: Говь-Алтай аймгийн Цээл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчид нэгтгэгддэг нэгж байгууллагын тухайд "Аймгийн хэмжээний усны эрэлт нийлүүлэлт хөрөнгө оруулалтын өнөөгийн үнэ цэнэ" гүйцэтгэлийн аудитаар өгөгдсөн 2020 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн "Төлбөр барагдуулах тухай" 07/163 дугаартай 56.3 сая төгрөгийн төлбөрийн актаас өнөөдрийн байдлаар 37.1 сая төгрөгийг барагдуулаагүй байна

Хэрэгжээгүй шийдвэрийн тухайд байгууллагын удирдлагад биелэлт ирүүлэх албан бичиг хүргүүлсэн боловч харилцан тооцоо нийлээгүй тул дахин мэдэгдэх хуудас хүргүүллээ. Цаашид санхүүгийн ажилтны хариуцлагыг сайжруулан зөрчлийг давтан гаргахгүй байж өмнөх аудитын шийдвэрийг хангаж ажиллах нь зүйтэй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цээл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн тухайд нэгтгэгддэг нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлт, төсвийн хэмнэлтийн горимын хэрэгжилт, болон аймаг дахь Төрийн аудитын газраас санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актыг хэрэгжүүлж цаашид аудитаар илэрсэн зөрчлийг бүс нутгийн хэмжээнд таслан зогсоох зохион байгуулалтын ажил хийх нь зүйтэй. Дараагийн аудитаар нэгтгэгддэг нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлт шууд бичилтээр хийсэн гүйлгээ, худалдан авалтад бүрдүүлж буй и баримтын цахим бүртгэл, 2 ба түүнээс дээш байгууллага хариуцан ажиллаж байгаа нягтлан бодогчийн хавсран гүйцэтгэж байгаа байгууллагаас авсан цалинг онцлон үзэх шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллага, 1 санд дүгнэлт гаргаж, 2 байгууллага, 2 сангийн ажил гүйлгээг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 4, “Хязгаарлалттай” 1 (сумын Засаг даргын тамгын газар) дүгнэлт өгсөн байна.

Дүгнэлт гарсан нэгж байгууллагын аудитын илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг аудитын дүгнэлт гарсан нэгж байгууллагуудад 110.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 16.6 сая төгрөгийн алдааг залруулж, 1.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон, 92.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Аудитаар өгөгдсөн шийдвэрийг чанартай биелүүлж, нотлох баримтаар дэмжигдсэн хэрэгжилтийг өгөгдсөн хугацаанд ирүүлэхийг анхаарах хэрэгтэй.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 1.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн ба үүнд 1.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийгээгүй болно.

Түүвэрт хамрагдсан байгууллагын тайланд хийгдсэн залруулга:

Түүвэрт хамрагдсан сумын ИТХ нь шүүхийн шийдвэрээр 7.5 сая төгрөгийн цалингийн нөхөн олговор олгосон боловч санхүүгийн тайланд авлагаар бүртгээгүй байсан тул аудитаар залруулсан.

4.2 Төвлөрүүлэн захирагчийн Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.3 Төвлөрүүлэн захирагчийн Албан шаардлага

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хувьд:

Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг гаргахад хөрөнгийн орлогыг 1.0 сая төгрөгөөр тасарсан нь Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 10 дугаар тогтоол, Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-т "Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Түүвэрт хамрагдсан байгууллага:

Цээл сумын ИТХ:

Зардлын зүйл анги зөрчиж хийсэн 6.2 сая төгрөгийн гүйлгээ хийсэн нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тогтоол, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7-т "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг

хариуцах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Батлагдсан төсвийг 10 хувиас доошгүй хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.1-т "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Шүүхийн шийдвэрийн 7.6 сая төгрөгийн цалингийн нөхөн олговрыг барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулаагүй нь Захиргааны ерөнхий хуулийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ." Хөдөлмөрийн тухай хуулийн 132.1-т "Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцдаа өөрийн буруугаас байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан ажилтанд сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ." 103.2-т "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Цээл сумын Соёлын төв:

Татварын тодорхойлолтоор 0.1 сая төгрөгийн дутуу, 1.0 сая төгрөгийн илүү төлөлттэй боловч санхүүгийн тайланд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Батлагдсан төсвийг 10 хувиас доошгүй хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.1-т "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

4.4 Төвлөрүүлэн захирагчийн Зөвлөмж

Санхүүгийн нэгтгэсэн тайлан: Зөвлөмж өгөгдөөгүй болно.

Түүвэрт хамрагдсан байгууллага:

Аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

ГАА-2022/15/-НА-СТА-ТТЗ

Цээл сумын ИТХ:

1. **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**
- 1.1. **Илрүүлэлт:** Тайлант онд бүртгэгдсэн 7.5 сая төгрөгийн өрийг бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт мэдээлээгүй, харилцагч байгууллагатай тооцоо нийлэх асуудалд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.
- 1.2. **Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.8-т “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалтыг мөрдөн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
Төсвийн төвлөрүүлэн захирагч											
Цээл сумын төвлөрүүлэн захирагч		3	1.0					3	1.0		
Түүвэрт хамрагдсан байгууллага											
Соёлын төв		2	1.0					2	1.0		
ИТХ		5	13.7	1	7.5			3	6.2	1	
Дүн		10	15.7	1	7.5			8	8.2	1	
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
Төсвийн төвлөрүүлэн захирагч											
Дүн											
Соёлын төв											
ИТХ											
Дүн											
Нийт дүн		10	15.7	1	7.5			8	8.2	1	



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

20 22 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 08/181

Алтай хот

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Говь-Алтай аймгийн Цээл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Батлагдсан төсвийг 10 хувиас доошгүй хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.1-т "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр 21.1 дэх заалт /Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хэмнэлтийн горимыг баримтлан ажиллаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх.
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цээл сумын Соёлын төвийн эрхлэгч (Э.Алтаншагай), нягтлан бодогч (Б.Баялагмаа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР
Д.ЭРДЭНЭЧИМЭГ
Б.ЦЭЦЭГМАА



¹ Говь-Алтай аймаг Есөнбулаг сум Баянхайрхан баг. Утас 70484030

07743492



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

20 22 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 06/181

Алтай хот

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Говь-Алтай аймгийн Цээл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг гаргахад хөрөнгийн орлогыг 1,037.8 мянган төгрөгөөр тасарсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-т "Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 10 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр 21.1 дэх заалт /Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө/. Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Орлогын төлөвлөгөөг бодит тоо судалгаанд үндэслэн боловсруулж хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэх
- Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цээл сумын Засаг дарга (Д.Буянхишиг), санхүүгийн албаны дарга (М.Дадымаа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР
Д.ЭРДЭНЭЧИМЭГ
Б.ЦЭЦЭГМАА



¹Говь-Алтай аймаг Есөнбулаг сум Баянхайрхан баг Утас 70484030

07042486



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 05/191

Алтай хот



ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ



Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Говь-Алтай аймгийн Цээл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Татварын тодорхойлолтоор 71.0 мянган төгрөгийн дутуу, 1,006.6 мянган төгрөгийн илүү төлөлттэй боловч санхүүгийн тайланд тусгаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр 21.1 дэх заалт /Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Татварын тодорхойлолтын зөрүүг арилган тооцоо нийлж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэх
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цээл сумын Соёлын төвийн эрхлэгч (Э.Алтаншагай), нягтлан бодогч (Б.Баялагмаа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР
Д.ЭРДЭНЭЧИМЭГ
Б.ЦЭЦЭГМАА



¹ Говь-Алтай аймаг Есөнбулаг сум Баянхайрхан баг Утас 70484030

07042482



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

20 22 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 04/87

Алтай хот

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Говь-Алтай аймгийн Цээл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Шүүхийн шийдвэрээр Цээл сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас Г.Болдод олгосон 7,506.4 мянган төгрөгийн цалингийн нөхөн олговор болох төсөвт учирсан хохирлыг нөхөн төлүүлээгүй.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ." Хөдөлмөрийн тухай хуулийн 132.1-т "Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцдаа өөрийн буруугаас байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан ажилтанд сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ." 103.2-т "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна" гэж заасантай нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр 21.1 дэх заалт /Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цалингийн нөхөн олговрыг барагдуулж, биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Намсрай)-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР
Д.ЭРДЭНЭЧИМЭГ
Б.ЦЭЦЭГМАА



¹ Говь-Алтай аймаг Есөнбулаг сум Баянхайрхан баг Утас 70484030



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

20 22 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 03/181

Алтай хот

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Говь-Алтай аймгийн Цээл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Зардлын эдийн засгийн ангилал зөрчиж 6,269.0 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.7-т "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тогтоолтой нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр 21.1 дэх заалт /Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Төлөөлөгчийн урамшууллыг олгохдоо зохих зардлын эдийн засгийн ангиллаас гарган ажиллаж, биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэх.
- Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цээл сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албаны дарга (Г.Болд) нягтлан бодогч (Г.Чоймаа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР
Д.ЭРДЭНЭЧИМЭГ
Б.ЦЭЦЭГМАА



¹ Говь-Алтай аймаг Есөнбулаг сум Баянхайрхан баг Утас 70484030

07042473



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 02/181

Алтай хот

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Говь-Алтай аймгийн Цээл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Батлагдсан төсвийг 10 хувиас доошгүй хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.1-т "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасныг зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр 21.1 дэх заалт /Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хэмнэлтийн горимыг баримтлан ажиллаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх.
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цээл сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албаны дарга (Г.Болд) нягтлан бодогч (Г.Чоймаа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР
Д.ЭРДЭНЭЧИМЭГ
Б.ЦЭЦЭГМАА



¹ Говь-Алтай аймаг Есөнбулаг сум Баянхайрхан баг Утас 70484030

07343470



ЦЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Д.БУЯНХИШИГ ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.03.25 № 256
танай _____ -ны № _____ -т

Биелэлт ирүүлэх тухай

Танай байгууллага нь манай байгууллагаас 2020 онд "Аймгийн хэмжээний усны эрэлт, нийлүүлэлт, хөрөнгө оруулалтын өнөөгийн үнэ цэнэ"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар тогтоосон 2020 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 07/163 дугаартай 37,050.0 мянган төгрөгийг төсвийн орлого болгох тухай төлбөрийн актын шийдвэрийн биелэлтийг заасан хугацаанд ирүүлэх ёстой байсан боловч өнөөдрийг хүртэл хэрэгжүүлээгүй байна.

Иймд уг шийдвэрийг биелүүлэн хэрэгжилтийг албан бичгээр нотлох баримтын хамт 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Заасан хугацаанд хариу ирүүлээгүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж заасны дагуу эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлэхийг үүгээр мэдэгдэж байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.ТҮВШИНБАЯР

07020520